



# МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ

## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨТӨЛБӨР

### ХӨТӨЛБӨРИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Аялал жуулчлал, зочлох үйлчилгээ, үйлчилгээний салбарын бизнесийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж хэрэгжүүлэх, Монгол орны түүх, соёл, байгаль орчин, газарзүйн хүрээний өргөн мэдлэгтэй, Англи ба Япон хэлтэй, үйлчилгээний технологи, харилцааны соёл болон мэдээллийн технологийг хэрэглэх мэдлэг, ур чадварыг эзэмшсэн мэргэжилтэн байна.

### ХӨТӨЛБӨРИЙН ДАВУУ ТАЛ

Хөтөлбөрийн онцлог нь үндэсний (БМИҮЗ) хэмжээнд болон олон улсын (ACBSP) түвшинд магадлан итгэмжлэгдсэн, Япон ба Европын орнуудад мэргэжлийн цалинтай дадлага 1 жил ба түүнээс дээш хугацаагаар хийх, Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг, Засгийн газраас тодорхойлсон хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй мэргэжлийн жагсаалтад орсон мэргэжил юм.

### ЭЕШ-ЫН ОНОО

Суурь - 490 оноо

Математик, Газарзүй, Нийгэм судлал, Англи хэл

Дагалдан - 490 оноо

Ур чадвар



Холбоо барих 99045142, 99080961

### АЖЛЫН БАЙР

Аялал жуулчлалын байгууллагууд, тур оператор, тур агентийн менежер, мэргэжилтэн, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн яам, хот, аймаг, сумын аялал жуулчлалын газарт мэргэжилтэн, зочид буудал, зоогийн газрын менежер, мэргэжилтэн, зохион байгуулагч, аяллын хөтөч-тайлбарлагч, энтертайнмент, шоу бизнес, эвент менежер, үйлчилгээний бизнесийн байгууллагын удирдах ажилтан, мэргэжилтнээр ажиллана.